

## ГАДААД ХУДАЛДАА БА ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДАЛ

Н.Батнасан<sup>1</sup>

**Хураангуй:** Энэхүү өгүүлэлд Монгол улс дахь гадаад худалдаа болон үндэсний аюулгүй байдлын харилцан хамаарлыг судалж, үндэсний аюулгүй байдлыг дээшлүүлэхийн тулд гадаад худалдааны чиглэлээр хэрэгжүүлэх бодлого, арга хэмжээнүүдийг тусгахыг зорив.

**Түлхүүр үгс:** олон улсын худалдаа ба үндэсний аюулгүй байдал, зах зээлээс хараат байдал, зах зээлээс хараат байдал, экспортын гол нэрийн бүтээгдэхүүнээс хараат байдал

**Abstract:** This article investigates relationship between international trade and national security in Mongolian context and aims to determine international trade policies and measures needed to improve and protect national security.

**Key words:** international trade and national security, market dependency, dependency from major export items

---

\* МУИС-ийн Бизнесийн сургууль (Email) batnasan\_n@hotmail.com

## Онолын судалгааны тойм

Хэдийгээр үндэсний аюулгүй байдлын талаар нийтээр хүлээн зөвшөөрсөн тодорхойлолт байхгүй боловч улс орон бүрийн хөгжлийн өвөрмөц онцлог, тулгарч буй асуудлын ялгаанаас шалтгаалан түүнийг янз бүрээр тодорхойлох оролдлого хийсээр иржээ.

“Хүйтэн дайн”-ы үед үндэстний аюулгүй байдлыг нэг улсын ашиг сонирхлыг өөр бусад орны дайралтаас хамгаалахтай холбож үздэг байв. Тухайлбал, Бреннан (1961)<sup>2</sup> үндэсний аюулгүй байдлыг улс үндэстний амьдрах чадвартай холбож үзсэн бол Рэй (1987)<sup>3</sup> үүнийг өөрийгөө хамгаалах чадварыг бэхжүүлэхтэй холбоотой асуудал гэж үзжээ. Очочи (1998)<sup>4</sup> үндэсний аюулгүй байдлыг хангахын тулд цэрэг, зэвсэглэлийг сайжруулах асуудалд төвлөрч анхаарах ёстой гэж үзсэн байна.

Орчин үед үндэсний аюулгүй байдлын асуудлаархи концепци бүхлээрээ өөрчлөгдөж, энэ асуудлыг үндэсний хөгжлийн урт хугацааны зорилго зорилтуудтай холбож үзэх болсон. Үндэсний аюулгүй байдлын талаархи ойлголт нэг улсын хүрээнээс хальж улс хоорондын харилцааг хамрах болсон төдийгүй улс хоорондын найрсаг харилцааг сэргээн хөгжүүлэх явдлыг үндэсний аюулгүй байдлыг хангах чухал арга хэмээн үзэх боллоо.

Давид Яблински үндэсний аюулгүй байдал бол учирч болзошгүй аюул заналаас үндэсний үнэт зүйлсээ хамгаалах буюу зайлсхийх боломж олгож чадах үндэсний болон олон улсын улс төрийн нөхцөл байдлыг бий болгоход чиглэсэн төрийн бодлогын хэсэг гэж үзсэн байна.<sup>5</sup> Маттью (1989)<sup>6</sup> бүтээлдээ ертөнц дахины хөгжил үндэсний аюулгүй байдлын асуудлыг байгалийн нөөц баялаг, хүрээлэн буй орчин, хүн амзүйн асуудлаар хүрээгээ тэлэхийг шаардах боллоо гэж дурдсан. Харин Асад (2007)<sup>7</sup> үндэсний аюулгүй байдлыг дан ганц цэрэг зэвсгийн асуудалтай холбож үзэх нь өрөөсгөл бөгөөд нийгэм, эдийн засаг, соёл, хөгжил шинэчлэл, үндэстний нэгдэл нягтралтай холбоотой асуудлууд үүний салшгүй хэсэг гэж өгүүлжээ.

Асар өргөн хүрээг хамарсан үндэсний аюулгүй байдлын асуудлыг нэгэн бэсрэг өгүүллийн хүрээнд судлан үзэх боломжгүй бөгөөд зохиогчийн зүгээс үндэсний аюулгүй байдлын талаар ямар нэгэн тодорхойлолт шинээр нэмэхийг

<sup>2</sup> Brennan, D. (1961). Setting the goals of arm control. In Brennan (ed.) Arms control, disarmament and national security. New York: George Brazillie.

<sup>3</sup> Ray, J. (1987). Global Politics. 3rd ed. Boston: Houghton Mifflin.

<sup>4</sup> Ochoche, S. (1998). The Military and National Security in Africa. In Hutchful (Ed.) Military and Militarism in Africa. Senegal:Codesirea

<sup>5</sup> Jablonsky, D. (2001). National power. In Cerami, J.R., Holcomb, J.F, Jr. (eds). U.S. Army war college guide to strategy.

<sup>6</sup> Mathew, J.T. (1989). Redefining security. New York: Foreign Affairs.

<sup>7</sup> Asad, D. (2007). National affair, retrieved September 2007

хүсээгүй юм. Харин зохиогч энэхүү өгүүлэлдээ Монгол улсын үндэсний аюулгүй байдалтай холбоотой гадаад худалдааны зарим чухал асуудлыг хөндөж тусгахыг зорьсон болно.

### **Гадаад худалдаанаас үндэсний аюулгүй байдалд үзүүлж буй олон талт нөлөөллийн тухайд**

Багтаамж багатай жижиг зах зээл, байгаль цаг уурын эрс тэс уур амьсгал, олон улсын далай тэнгис, зам харилцаанаас алслагдсан байршил, эдгээрээс үүдэлтэй үйлдвэрлэлийн болон тээвэрлэлтийн өндөр өртөг зардал нь Монголд үр ашигтай үйлдвэрлэл эрхлэх боломжийг хязгаарлаж, эдийн засгийн олон салбарыг хөгжүүлэх боломжийг боомилж байдаг. Үүнээс үүдэлтэйгээр Монголын эдийн засаг өрсөлдөх чадвартай цөөн салбар, хэдхэн төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлд төвлөрч, улс орон бүхэлдээ гадаад зах зээл, гадаад орчноос хэт хамааралтай эмзэг, аюултай нөхцөл байдалд орсон байна. Улс орны хөгжил сул дорой байгаагаас хүнс, шатахуун, үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж, түүхий эд материал зэрэг хэрэгцээт бараа таваараа гадаад зах зээлээс, түүний дотор хоёр том хөрш орноосоо гол төлөв худалдан авч байгаа нь үүссэн бэрхшээлтэй нөхцөл байдлыг улам бүр дэвэргэж байдаг.

Эдийн засгийн бүхий л салбарыг хөгжүүлэх боломжгүй Монгол шиг орны хувьд гадаад худалдаа нь улс орны улс төр, эдийн засаг, нийгэм-соёлын болон батлан хамгаалах, хүний аюулгүй байдалтай олон шижмээр холбоотой байна. Ялангуяа гадаад худалдааны тарифын болон тарифын бус зохицуулалтаар дамжуулан үндэсний үйлдвэрлэлийг хамгаалах, стратегийн ач холбогдол бүхий шинэ залуу салбаруудыг хамгаалж хөгжүүлэх, хүн амын хөдөлмөр эрхлэх нөхцлийг хамгаалж, ажлын байруудыг хадгалж үлдээх боломжтой байдаг тул эдийн засгийн аюулгүй байдал нь гадаад худалдаатай маш өргөн хүрээнд холбоотой байна.

Худалдаагаар дамжуулан үндэсний эдийн засгийн тогтвортой хөгжлийг хадгалж, улсын дотоодын үйлдвэрлэл хэрэглээ тогтвортой хэвийн явагдах нөхцлийг бүрдүүлдэг. Худалдаанаас олох орлого нь улсын валютын орлогыг бий болгож, төсвийн орлогын багагүй хэсгийг бүрдүүлдэг. Түүнчлэн үндэсний хэмжээнд бүтээгдсэн техник, технологийн ололтуудыг хамгаалж, үр шимийг нь хүртэхэд оюуны өмчтэй холбоотой худалдаа чухал үүрэгтэй. Үйлчилгээний худалдаанд хамаарах аялал жуулчлал, тээвэр, даатгалын болон бусад үйлчилгээ нь улсын эдийн засгийн тогтвортой байдлыг хамгаалахад чухал үүрэг гүйцэтгэж, валютын орлогын чухал эх үүсвэр болж байдаг.

Худалдаа нь аюултай болон хортой бодисуудын үйлдвэрлэл, хэрэглээ, тээвэрлэлт, хадгалалттай холбоотой байх тул байгаль орчны аюулгүй байдалтай бас холбогддог. Ялангуяа уул уурхайн олборлох үйлдвэрлэл хөгжсөн манайх

шиг орны хувьд химийн бодисын хэрэглээ байгаль орчинд ихээхэн хор хөнөөл учруулдаг. Үүнээс гадна цөмийн эрчим хүчний түүхий эдийг олборлож эхэлсэн нөхцөлд ийм төрлийн үйлдвэрлэлийн байгаль орчинд үзүүлэх хор хөнөөл асар их юм. Нүүрс, нефть гэх мэт эрчим хүчний түүхий эдийн үйлдвэрлэл, хэрэглээ нь байгаль орчинд хор хөнөөл ихтэй. Монгол улс нь нүүрс болон нефтийн худалдаанд оролцогч орон билээ. Хэдийгээр манай улс боловсруулаагүй нүүрс болон нефтийн аль алиныг нь гадаад зах зээлд экспортлогч орон боловч түлш шатахуун, эрчим хүчийг гаднаас худалдан авдаг орон юм. Сүүлийн жилүүдэд эрчим хүч, түлш шатахууны гадаад зах зээлээс хараат байдлыг бууруулах талаар өргөн хүрээнд яригдаж байгаа. Түлш, эрчим хүчний аюулгүй байдал ч гадаад худалдаатай бас холбоотой.

Манай улс байлдааны болон батлан хамгаалах, хууль сахиулахад шаардлагатай зэвсэг, техникийг дотооддоо үйлдвэрлэдэггүй тул энэ салбарт гадаад зах зээлээс бүрэн хамааралтай бөгөөд шаардлагатай бүх зэвсэг, тоног төхөөрөмжийг гадаад зах зээлээс худалдан авч байна. Хүний аюулгүй байдлын талаас харвал хүнсний хэрэглээнийхээ багагүй хэсгийг гаднаас худалдан авдаг манай орны хоол хүнсний эрүүл ахуй, аюулгүй байдал нь гадаад худалдаанаас ихээхэн хамааралтай. Хэрэглээний, түүний дотор стратегийн чухал ач холбогдол бүхий бараа таваарын хэрэглээ нь гадаад зах зээлээс хараат байдалтай байгаа явдал Монгол улсын үндэсний аюулгүй байдалд ноцтой эрсдэл учруулж байдаг.

Сүүлийн жилүүдийн гадаад худалдааны тоо баримтуудаас үзэхэд, 2001-2016 онд эм болон эмийн бүтээгдэхүүний импорт 7.08 сая ам.доллараас 90.87 сая ам.доллар хүртэл 12.84 дахин, химийн бордооны хэрэглээ 1.74 сая ам.доллараас 22.46 сая ам.доллар хүртэл 12.89 дахин өссөн бол химийн бодисийн импорт 8.14 сая доллараас 34.47 сая доллар хүртэл 4.24 дахин, тэсэрч дэлбэрэх бодисийн импорт 1.3 сая ам.доллараас 6.74 сая ам.доллар хүртэл 5.17 дахин тус тус өсчээ.<sup>8</sup> Гэтэл дээрх хугацаанд улсын хүн ам 2442.5 мянгаас<sup>9</sup> 3119.9 мянга хүртэл 27.7 орчим хувиар өссөн байна.<sup>10</sup>

Ийнхүү Монголчууд эм, эмийн бүтээгдэхүүнийг урьд өмнөхөөс ихээр хэрэглэх болсны зэрэгцээ хүн амын хоол хүнсний хэрэглээнд химийн бордоо хэрэглэсэн газар тариалангийн бүтээгдэхүүний хэрэглээ нэмэгдсэн зэрэг нь хүн амын эрүүл мэнд, удмын санд ноцтой хохирол учрах эрсдлийг бий болгосон. Төрөл бүрийн согтууруулах ундаа, амины импорт өндөр хэмжээнд байгаагийн зэрэгцээ сүүлийн үеийн баримтууд Монголд хар тамхийг гаднаас оруулж, худалдаалах эрсдэл улам бүр нэмэгдэх шинжтэй болсныг харуулна. Импортлосон химийн бодис, тэсэрч дэлбэрэх бодис хүрээлэн буй орчин,

<sup>8</sup> ОУХТ-ийн гадаад худалдааны статистик мэдээлэлд тулгуурлан зохиогчийн хийсэн тооцоо. Эх сурвалж: WTO/UNCTAD International Trade Center: Trade map 2016

<sup>9</sup> ҮСХ. "Монгол улсын статистикийн эмхтгэл – 2001" УБ 2002.

<sup>10</sup> ҮСХ. "Монгол улсын статистикийн эмхтгэл – 2016" УБ 2017

экологийн нөхцөл байдалд ноцтой хөнөөл учруулах хэмжээнд очсоны зэрэгцээ хүн ам, нийгэмд аюул занал учруулж болзошгүй хэмжээнд очсоныг анхаарахгүй өнгөрөөж болохгүй юм. Энэ бүх баримтууд үндэсний аюулгүй байдлыг хангахын тулд гадаад худалдаанд тавих хяналт, зохицуулалтыг сайжруулах зайлшгүй шаардлага байгааг харуулж байна.

### **Үндэсний аюулгүй байдалд гадаад худалдааны үзүүлэх зарим нөлөөллийг үнэлэх боломж**

Олон улсын хэмжээнд эдийн засгийн гадаад харилцаа, түүний дотор гадаад худалдаан дахь эмзэг, аюулгүй байдлыг олон үзүүлэлтээр хэмждэг. Дээр дурдсан олон үзүүлэлтүүдийн дотроос улсын эдийн засгийг бүхэлд нь донсолгож, улс орны үйлдвэрлэл, хэрэглээ, улсын төсвийн орлого зарлагад шууд нөлөөлдөг гадаад худалдааны зарим нөлөөлөл, тэдгээрийг үнэлэх зарим боломжийн талаар бид энд өгүүлэх гэж байна.

Үүнд юуны түрүүнд тухайн улс орны эдийн засгийн хөгжлийн хүрсэн түвшин, эдийн засгийн олон салбарыг зэрэг хөгжүүлж, нэг салбараас хамаарах хамаарлаа бууруулж чадсан эсэхийг харуулдаг чухал үзүүлэлт болох тухайн улс орны экспорт, импортын бараа бүтээгдэхүүний төвлөрлийн индексийн талаар өгүүлэе. Экспортын бараа бүтээгдэхүүний төвлөрлийн индексийн утга нэг рүү ойртох нь тухайн улс орны эдийн засаг нь ганц, эсвэл цөөн төрлийн бараанаас хэт хамааралтай болохыг, тухайн орны эдийн засгийн нэг буюу цөөхөн салбар нь өрсөлдөх чадвар сайтай, бусад нь өрсөлдөх чадвар султай байгааг харуулдаг. Харин импортын хувьд индексийн утга нэгд ойрхон байх нь тухайн орны эдийн засаг цөөн нэрийн бараа бүтээгдэхүүнээс хараат байдалтай, эдийн засгийн салбаруудынх нь өрсөлдөх чадвар сул байгаагаас хамаарч улс орнуудтай салбар доторхи худалдаа хийж байгааг харуулна. Түүнчлэн гадаад худалдаанд томоохон хувийг эзэлдэг нефть, байгалийн хий гэх мэт бүтээгдэхүүнийг бүгдийг нь гаднаас худалдан авдаг орнуудад индексийн утга нэг рүү ойртох магадлалтай.

Түүнчлэн экспорт, импортын гадаад зах зээлээс хараат байдлыг харуулдаг экспортын болон импортын зах зээлийн төвлөрлийн индексүүд нь эдийн засгийн гадаад харилцааны эмзэг, аюулгүй байдлыг харуулах чухал үзүүлэлтүүд болно. Тухайн улс орны экспорт, импортод цорын ганц буюу цөөхөн улс орон давамгайлах байдалтай нөхцөлд индексийн утга нэгд ойртоно. Ийм байхад тухайн улс орон экспорт, импортоороо дамжин худалдааны гол түнш орныхоо зах зээл, эдийн засгийн нөхцөл байдлаас хамааралтай болж хувирдаг. Харин олон улс оронтой эрх тэгш худалдааг хөгжүүлж чадсан нөхцөлд зах зээлээс хараат байдлын индексийн утга нь 0-рүү ойртоно.

Бид энэхүү судалгааны ажлын хүрээнд дээрх индексүүдийг Herfindahl

— Hirschman-ны зах зээлийн төвлөрлийг тооцох индекс (HNI)-ийн аргыг ашиглан тооцоолов.

Экспортын барааны төвлөрлийн индексийг дараахь томъёогоор тооцоолов.

$$HNI = \sum_{i=1}^n X_i^2 / X^2$$

$X_i$  —  $i$  барааны экспорт

$X$  — нийт экспорт

Харин импортын барааны төвлөрлийн индексийг дараахь томъёогоор тооцоолов.

$$HNI = \sum_{i=1}^n M_i^2 / M^2$$

$M_i$  —  $i$  барааны импорт

$M$  — нийт импорт

Эдгээр индексүүдийг ДХБ/НҮБХХБ-ын дэргэдэх Олон улсын худалдааны төвөөс гаргасан 2016 оны гадаад худалдааны статистик мэдээллийг ашиглан, Бараа тодорхойлох, кодлох уялдуулсан систем (БТКУС) — ийн 97 бүлгээр задалсан, хоёр орны ангиллын түвшинд тооцоолсон болно. ОУХТ — ийн мэдээллийн сангаас дэлхийн 240 гаруй улс орнуудаас НҮБ-д гишүүнчлэл бүхий орнуудыг сонгон авч, мэдээллийг түүвэрлэн тооцооллыг үйлдсэн. ОУХТ-ийн мэдээллийн санд Лихтенштейн, Монако, Сан Марино улсуудаас бусад НҮБ-ийн гишүүн 189 орны орны гадаад худалдааны статистик мэдээллийг тооцоолон оруулсан байв.

Гадаад зах зээлээс хараат байдлыг харуулсан экспортын зах зээлийн төвлөрлийн индексийн доорхи томъёогоор тооцоолов.

$$HNI = \sum_{i=1}^n X_{ij}^2 / X^2$$

$X_{ij}$  —  $j$  улсад экспортлож буй  $i$  барааны импорт

$X$  — нийт экспорт

Гадаад зах зээлээс хараат байдлыг харуулдаг өөр нэг үзүүлэлт болох импортын зах зээлийн төвлөрлийн индексийн доорхи томъёогоор тооцоолов.

$$HHI = \sum_{i=1}^n M_{ij}^2 / M^2$$

$M_i$  –  $i$  улсаас импортлож буй  $j$  барааны импорт


$M$  – нийт импорт

Эдгээр индексүүдийг тооцоолохдоо НҮБ-ийн гишүүн 192 орноос 189 орны 2016 оны экспорт, импортын статистик үзүүлэлтийг ОУХТ-ийн мэдээллийн сангаас худалдааны бүх түнш орнуудаар нь түүвэрлэн авч, тооцооллыг үйлдсэн болно.

Тооцоолоос үзэхэд экспортын барааны төвлөрлийн индекс 0.2960, импортын барааны төвлөрлийн индекс 0.0858, экспортын зах зээлийн төвлөрлийн индекс 0.7031, импортын зах зээлийн төвлөрлийн индекс 0.2136 байлаа. Тооцооноос үзэхэд, экспортын зах зээлийн төвлөрлийн индексийн утга маш өндөр, экспортын барааны төвлөрлийн индекс болон импортын зах зээлийн төвлөрлийн индексийн утгууд дунд зэрэг, импортын барааны төвлөрлийн индексийн утга доогуур хэмжээнд байна. Эдгээр эмзэг аюулгүй байдлын үзүүлэлтээр НҮБ-ын гишүүн 189 орны дотор эзэлж буй байрыг авч үзвэл, экспортын барааны төвлөрлийн индексээр 55-р байрт, импортын барааны төвлөрлийн индексээр 33-р байрт, экспортын зах зээлийн төвлөрлийн үзүүлэлтээр 9-р байрт, импортын зах зээлийн төвлөрлийн үзүүлэлтээр 29-р байрт тус тус жагсаж байна.

Олон улсын харьцуулсан үзүүлэлтээс харахад, аль ч үзүүлэлтээр Монгол улс нэлээд дээгүүр байрт орж байгаа ба эдгээр нь манай орон гадаад худалдааны хувьд гол түнш орнуудаасаа, гол нэрийн бүтээгдэхүүнүүдээсээ нэлээд хараат байдалд орсныг нотолж байна. Монгол улсын экспортын барааны төвлөрлийн индексийн тоон утга бусад индекстэй харьцуулахад харьцангуй сайн байгаа нь экспорт нэр төрлийн хувьд өргөжиж байгааг харуулж байгаа боловч экспортын зах зээлийн хувьд нэг орноос хэт хамааралтай хэвээр байна.

Бараа, үйлчилгээний худалдаан дахь экспортын салбарын бүтэц/2016 онд




Монгол улс бүтээгдэхүүний боловсруулалтын түвшин, тээвэрлэлтийн өндөр өртөг зардал зэргээс шалтгаалан экспортын бүтээгдэхүүнээ газарзүйн ойр дөт байршилтай орнуудад, ялангуяа БНХАУ-д голлон худалдаалдаг. 2016 оны байдлаар Монгол улс 4916.3 сая ам.долларын бараа экспортлож, 3339.6 сая ам.долларын барааг импортлосон бөгөөд экспортын 79.0%, импортын 31.1% нь БНХАУ-д, экспортын 1.1%, импортын 25.8% нь ОХУ-д ногдож байв.<sup>11</sup> Цөөн нэрийн бүтээгдэхүүн, зах зээлээс хараат байдал нь Монголын эдийн засагт давж гарахад хэцүү хана хэрэм болж байдаг.

Энэ байдлаас шалтгаалан экспортын бүтээгдэхүүнээ зах зээлийнхээс хэт доогуур үнээр зарах, импортлох бараа таваараа зах зээлийнхээс хэт дээгүүр үнээр худалдан авдаг болсоор олон жил өнгөрч байна. Зөвхөн 2016 онд нийт экспортод 59.9%-ийг эзэлж байсан зэс, зэсийн баямал, нүүрс, жоншны баяжмалыг дэлхийн зах зээлийнхээс хэт доогуур гэж хэлж болох үнээр худалдаалснаас 1145.4 сая ам.долларын, нийт импортод 15.3%-ийг эзэлж байсан бензин болон дизелийн түлшийг зах зээлийнхээс хэт дээгүүр худалдан авснаас 87.8 сая ам.долларын алдагдал хүлээжээ.<sup>12</sup>

<sup>11</sup> ОУХТ-ийн гадаад худалдааны статистик мэдээлэлд тулгуурлан зохиогчийн хийсэн тооцоо. Эх сурвалж: WTO/UNCTAD International Trade Center: Trade map 2016

<sup>12</sup> ОУХТ-ийн гадаад худалдааны статистик мэдээлэлд тулгуурлан зохиогчийн хийсэн тооцоо. Эх сурвалж: WTO/UNCTAD International Trade Center: Trade map 2016





Эдгээр баримт цаашид бодлогын түвшинд экспортын зах зээлээс хараат байдлаа бууруулах, гадаад худалдааныхаа түншийн хүрээг өргөжүүлэх, эдийн засгийн гадаад харилцааны хувьд олон тулгуурт бодлого явуулах, үүнийгээ зарим улс оронтой Чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулах, бүс нутгийн хэлэлцээрт нэгдэх зэргээр хэрэгжүүлэх нь зайлшгүй чухал болоод байгааг нотолж буй хэрэг юм.

Улс төрийн аюулгүй байдлын хүрээнд гадаад худалдааны бодлого нь Монгол улсын олон тулгуурт гадаад бодлогын чухал бүрэлдэхүүн хэсэг нь болж, цөөхөн улс орон, цөөн нэрийн бараа бүтээгдэхүүнээс хараат байдлыг бууруулах гол зэвсэг нь болно.

### **Гадаад худалдаатай холбогдох үндэсний аюулгүй байдлын асуудлуудыг шийдвэрлэх гарцууд**

Үндэсний аюулгүй байдлыг хангах чиглэлээр хэрэгжүүлэх аливаа бодлого, арга хэмжээ нь үндэсний ашиг сонирхол, үндэсний хөгжлийн урт хугацааны зорилгод нийцсэн байх ёстой. Гадаад худалдаатай холбоотой үндэсний аюулгүй байдлын асуудлуудыг шийдвэрлэхэд ч ийм зарчмаар хандах хэрэгтэй. Дээр өгүүлсэнчлэн тулгарч буй асуудлууд олон, түүнийг шийдвэрлэх арга замууд нь ялгаатай боловч тэдгээрийг харилцан уялдаатайгаар, үндэс сууриар нь шийдвэрлэх гарцыг хайх чухал юм.

Монголын эдийн засгийн өмнө тулгарч буй олон бэрхшээл, түүний дотор цөөхөн улс орон, цөөн бүтээгдэхүүнээс хараат байдал нь улс орны хөгжил, түүний дотор аж үйлдвэржилтийн түвшин доогуур, эдийн засгаа төрөлжүүлэн

хөгжүүлж чадаагүй зэрэгтэй шууд холбоотой. Түүнээс гадна газарзүйн алслагдмал байдал болон түүхий эд голлосон овор хэмжээ ихтэй бүтээгдэхүүнийг олон улсын зах зээлд худалдаалдаг зэргээс шалтгаалан тээвэрлэлтийн өртөг зардал өндөр, өрсөлдөх чадвар сул байгаатай ч холбоотой.

Тиймээс Монгол улс хөгжлийн бодлогын хүрээнд газарзүйн алслагдмал байдал, байгаль цаг уурын эрс тус уур амьсгал, тархай бутархай суурьшсан хүн ам бүхий жижиг зах зээл зэрэг тээврийн болон үйлдвэрлэлийн өртөг зардлыг нэмэгдүүлж, Монгол орны эдийн засгийн хөгжил, өрсөлдөх чадварт сөрөг нөлөөтэй тийм хүчин зүйлсийн нөлөөллийг сулруулах асуудлыг хамгийн түрүүнд анхаарч үзэх ёстой.

Худалдан авах чадвар сул, хүн ам цөөнтэй жижиг зах зээлд үйлдвэрлэгчид эдийн засгийн хувьд ашигтай ажиллах гол арга зам нь дотоодын зах зээлд бус, харин багтаамж ихтэй зах зээл рүү чиглэсэн бүтээгдэхүүнийг олон тоогоор үйлдвэрлэх явдал юм. Монгол улс эдийн засгийн бүхий л салбаруудыг хөгжүүлэх замаар бус, харин бизнесийн асар том орон зайд өөрийн үйлдвэрлэж чадах бүтээгдэхүүнүүд дотроосоо хамгийн бага өртөг зардалтайгаар үйлдвэрлэж чадах бүтээгдэхүүний үйлдвэрлэлээр төрөлжин, бусад улс орны мөн тийм бараа үйлчилгээг худалдан авч хэрэглэх замаар хөгжлөө түргэтгэх боломжтой билээ.

Монгол улсад нөөц баялагт тулгуурласан, харьцангуй давуу тал бүхий 2 том салбар бий. Тэдгээр нь нэгд, нэхмэл сүлжмэл, арьс шир боловсруулах, мах сүүний үйлдвэрлэл гэх мэт мал аж ахуйд тулгуурласан үйлдвэрлэлийн салбарууд, хоёрт, нүүрс, алт, зэс, нефть гэх мэт олборлох үйлдвэрлэлийн салбарууд юм.

Үйлдвэрлэлийн зардлыг бууруулах, өрсөлдөх чадварыг сайжруулахын тулд түүхий эдийн боловсруулалтын түвшинг нэмэгдүүлж, нэмүү өртөг бүтээх шат дамжлагаа олшруулах, эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, овор хэмжээний хувьд бага, үнийн дүнд нь тээврийн зардал бага хувийг эзэлдэг эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, шилдэг сайн технологи, арга ажиллагааг үйлдвэрлэлд нэвтрүүлэн ашиглах нь чухал. Аж үйлдвэржилт бол үндэсний эдийн засгийн томоохон эрсдэл болох цөөн улс орон, бүтээгдэхүүнээс хараат байдлыг бууруулах үндсэн арга зам нь юм. Гэвч аж үйлдвэрийг хэрхэн яаж хөгжүүлэх вэ гэсэн асуулт гарах нь зүй ёсны хэрэг юм.

Нобелийн шагналт Пол Кругман “Аж үйлдвэрийн зорилтот бодлого: онол ба баримтууд” гэсэн өгүүлэлдээ аж үйлдвэрийг хөгжүүлэхдээ 4 бүлэг хүчин зүйлст онцгойлон анхаарах хэрэгтэй гэж тэмдэглэсэн. Тэдгээр нь нэгд, нэг ажилтанд ногдох нэмэгдсэн өртгийн хэмжээ, хоёрт, бусад салбаруудтай холбогдсон байдал, гуравт, ирээдүйн өрсөлдөх чадвар, дөрөвт, бусад улс

орнуудын бодлого зэрэг болно.<sup>13</sup> Нэг ажилтанд ногдох нэмэгдсэн өртөг өндөртэй салбарт хөрөнгө оруулах нь улс орны нэмэгдсэн өртөг бүтээх чадвар, эдийн засгийн өсөлтийг түргэтгэх үндсэн арга зам юм. Харин нэг салбарын үйлдвэрлэлийн өсөлт бусад салбаруудын үйлдвэрлэлд шууд ба дам нөлөөлж, бусад салбаруудын үйлдвэрлэл, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлдэг байх нь түүнээс ч дутуугүй ач холбогдолтой. Түүнчлэн эдийн засгийн тогтвортой хөгжлийг хангах бодлогын хүрээнд ирээдүйд улс орны эдийн засгийг авч явах шинэ салбаруудын хөгжлийн үндэс суурийг тавих, хөгжүүлэх асуудлыг онцгойлон авч үзэх зайлшгүй шаардлагатай. Энэ хүрээнд биотехнологи, нефтьхими, атомын болон сэргээгдэх эрчим хүч, мэдээллийн технологи болон өөр бусад манай нөхцөлд хөгжүүлж болох өндөр технологийн шинэ залуу салбаруудад хөрөнгө оруулах зайлшгүй шаардлага бий бөгөөд ялангуяа тээвэрлэлтийн өндөр өртөг зардлаа бууруулахын тулд зайнаас хамаарал багатай үйлдвэрлэл, технологийг бий болгох, нутагшуулах асуудалд нухацтай анхаарах нь чухал байна. Түүнчлэн Монгол улс үйлдвэржүүлэх бодлогоо хэрэгжүүлэхдээ ижил бүтээгдэхүүнийг зах зээл дээр худалддаг өрсөлдөгчид, боловсруулсан бүтээгдэхүүн бус түүхий эд худалдан авахыг эрмэлдэж буй улс орнуудтай бус харин эдийн засгийн бүтцийн хувьд хоршин хөгжих боломжтой улс орнуудтай худалдаа, эдийн засгийн бодлогоо уялдуулан хөгжүүлэх шаардлагатай байгаа юм.

Үүнээс гадна хүн амын эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд хор хөнөөл учруулдаг эмийн бүтээгдэхүүн, бордоо, химийн болон тэсэрч дэлбэрэх бодисын импорт, худалдааг хянах зохицуулах оновчтой арга механизмыг нэвтрүүлэх, хил гаалийн хяналтын үр нөлөөг сайжруулахад чиглэсэн эрсдэлд суурилсан хяналтын тогтолцоог бий болгох зэрэг үр нөлөөтэй арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай байгаа юм.

Дээр бичсэн санаануудаа нэгтгэн дүгнэж үзвэл, улс орны үндэсний аюулгүй байдлыг хангах зорилгыг хэрэгжүүлэхийн тулд худалдааны бодлогын хүрээнд дараахь үндсэн арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх шаардлагатай болсон гэж дүгнэж болохоор байна.

Нэгд, худалдааны бодлого нь тарифийн болон тарифийн бус хориг саадуудыг арилгах, тээвэрлэлтийн өндөр өртөг зардлыг бууруулах замаар олон улсын эдийн засгийн харилцаанд илүү идэвхтэй байр сууринаас оролцох боломж нөхцлийг бүрдүүлэхэд чиглэх ёстой. Энэ хүрээнд юуны өмнө түүхий эдээ боловсруулах, ийм замаар тээвэрлэлтийн өндөр өртөг зардлыг бууруулах, өрсөлдөх чадвараа нэмэгдүүлэх, үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээ илүү үнэ хүрэх зах зээлд худалдаалах асуудлуудад анхаарах нь чухал байна. Цаашид бодлогын түвшинд экспортын зах зээлээс хараат байдлаа бууруулах, гадаад

<sup>13</sup> Paul R. Krugman "Targeted Industrial Policies: Theory and Evidence"

худалдааныхаа түншийн хүрээг өргөжүүлэх, эдийн засгийн гадаад харилцааны хувьд олон тулгуурт бодлого явуулах, үүнийгээ зарим улс оронтой Чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулах, бүс нутгийн хэлэлцээрт нэгдэх зэргээр хэрэгжүүлэх нь зайлшгүй чухал болсон. ЧХХ болон бүс нутгийн хэлэлцээрийг эдийн засгийн засгийн бүтцийн хувьд манай оронтой урт удаан хугацаанд хоршин ажиллах боломжтой улс орон, бүс нутгуудтай байгуулах хэрэгтэй.

Хоёрдугаарт, аж үйлдвэржилт бол үндэсний эдийн засгийн хараат байдлыг бууруулах, эдийн засгийн хөгжлийг тогворжуулах үндсэн арга зам юм. Аж үйлдвэржилтийн бодлогыг хэрэгжүүлэхдээ нэмэгдсэн өртөг бүтээх чадвар, бусад салбаруудын үйлдвэрлэлийг шууд болон дам байдлаар дэмжих нөлөө, тухайн салбарын хөгжлийн ирээдүйн боломж зэргийг харгалзах шаардлагатай. Капитал зарцуулалт ихтэй олборлох үйлдвэрлэлийн салбарт бий болсон орлогыг ядуурал ихтэй хөдөө орон нутагт, хөдөлмөр зарцуулалт ихтэй ХАА, үйлчилгээ гэх мэт салбарт хөрөнгө оруулалт болгон оруулахад чиглэсэн бодлогыг хэрэгжүүлж, ялангуяа ХАА-н түүхий эдийг боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих нь хөдөө аж ахуйн түүхий эдэд эрэлтийг бий болгох, энэ салбарын бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэхэд чухал ач холбогдолтой төдийгүй хот хөдөөгийн ялгааг багасгах, бүс нутгуудыг жигд тэнцвэртэйгээр хөгжүүлэхэд чухал ач холбогдолтой болно.

Гуравт, хүний эрүүл мэнд, байгаль орчинд хор хөнөөл учруулах эрсдэлтэй бараа бүтээгдэхүүний худалдаанд тавих хяналт зохицуулалтыг сайжруулахын зэрэгцээ эрсдэлд суурилсан, үр өгөөжтэй хяналтын тогтолцоог нэвтрүүлэх, хууль эрзүйн орчинд өөрчлөлт хийх замаар орлого, баялагийг зувчуулан ашиглах арга хэрэгсэл болсон “шилжүүлэх үнэ”-ийг зохицуулах зохицуулалтыг бий болгох, асуудлыг хамтатган авч үзэх шаардлагатай.

Дөрөвдүгээрт, эдийн засгийн тогтвортой хөгжлийг бий болгоход худалдааны бодлого чухал үүрэгтэй. Энэ хүрээнд нөөц баялагийн үр шимийг хойч үеийнхэнд үлдээх, ирээдүй байгаль орчныг хамгаалах зориулалттай сангуудыг байгуулж, экологид учруулсан хор хохирлыг арилгах буюу нөхөн төлүүлэхэд чиглэсэн татвар, тарифийг ашиглаж болох юм.

### **Ашигласан материал**

- [1] Batnasan Namsrai “Enhancing the Contribution of Preferential Trade Agreements to Inclusive and Equitable Trade: The Case of Mongolia” UNESCAP 2017
- [2] Batnasan Namsrai et al. “The possibility and importance of establishing Free Trade Agreements with the PRC and the Russian Federation.” Economic Development Ministry, UB, 2014

- [3] Edited by Keith Griffin., “Poverty reduction in Mongolia” Asia Pacific Press 2003
- [4] Edited by Selim Jahan and Batnasan Namsrai., “Human development textbook” UNDP 2007
- [5] Edited by Batnasan.N & Dolgorjav.Ya “Human development report of Mongolia – 2003: Urban-Rural Disparities in Mongolia” UNDP 2003
- [6] Edited by Batnasan.N & Bikales.B “Human development report of Mongolia – 2007: Employment and poverty in Mongolia” UNDP 2007
- [7] Enkhbayar Shagdar “Neo-liberal “shock therapy policy during the Mongolian economic transition” ERINA Discussion paper No 0703e.
- [8] Max. W Corden “The Dutch disease in Australia: Policy Options for a Three-Speed Economy” Melbourne Institute Working Paper Series., Working paper No 5/12., 2012
- [9] Paul R. Krugman “Targeted Industrial Policies: Theory and Evidence” 1983
- [10] S. R. Osmani “Towards an employment-oriented pro-poor development strategy for Mongolia: A background paper” UNDP 2007
- [11] Victor. E. Tokman “Globalisation in Chile: A Positive Sum of Winners and Losers” ICTSD issue paper No 14
- [12] UNIDO (2002), Mongolia: Industrial and Trade Development Policy Review. Report prepared for the Ministry of Trade, Government of Mongolia, on behalf of the United Nations Development Programme: Ulaanbaatar.
- [13] General Customs Administration of Mongolia “Foreign trade commodity statistics” 2009 - 2016
- [14] General Customs Administration of Mongolia “Foreign trade statistics “ 1995 - 2008
- [15] NSO “Mongolia in a market system” statistical yearbook 1989-2002
- [16] NSO “Statistical yearbook of Mongolia 2003– 2016”
- [17] ITC “Trade map” 2016